



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2014 оны 02 сарын 26 өдөр

Дугаар 60

Улаанбаатар хот

┌ “Хяргас хас” ХЗХ-ны хадгаламж, зээлийн үйл ┐
ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг сэргээх, сунгах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10.1.4, 6.2, 13.3, Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 60 дугаар тогтоолоор батлагдсан “Хадгаламж, зээлийн хоршооны зохицуулалтын журам”-ын 9.3 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Түдгэлзүүлсэн хугацаанд Хорооноос өгсөн үүрэг даалгаврыг биелүүлсэн тул “Хяргас хас” ХЗХ-ны хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг сэргээсүгэй.
2. Тус ХЗХ-ны тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаагаар сунгасугай.
3. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээнд сэргээсэн болон сунгасан талаарх тэмдэглэгээг 2014 оны 03 дугаар сарын 08-ны өдрийн дотор хийлгэхийг “Хяргас хас” ХЗХ /Б.Сарантуяа/-нд үүрэг болгосугай.
4. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

000061